/120./ Судсаар хэрэглэдэг тарилгын шингэнийг холиход үүсч болох үл нийцэлд аль нь хамаарагддаг вэ?

1. Адсорбцын үл нийцэл

2. Фармакологийн үл нийцэл
3. Температурын үл нийцэл
4. Физикийн үл нийцэл
5. Агаарын үл нийцэл

/121./ Гетероген тосон түрхэцэд ямар тосон түрхэцүүд хамаарагдах вэ?

1. суспенз хэлбэрийн тосон түрхэц
2. эмульс хэлбэрийн тосон түрхэц
3. хосолсон хэлбэрийн тосон түрхэц
4. уусмал хэлбэрийн тосон түрхэц
5. хайлш хэлбэрийн тосон түрхэц

/122./ Жинхэнэ уусмалын шинж чанарыг нэрлэнэ үү?

1. Гадна байдал нь тунгалаг
2. Жижиг хэсгүүд нь цаасан шүүлтүүрээр нэвтэрнэ.
3. Жижиг хэсгүүд нь ультра шүүлтүүрээр нэвтэрнэ.
4. Тогтвор сайтай
5. Жижиг хэсгүүд нь мембранаар нэвтэрнэ.

/123./ Хийн ариутгалын аргад хэрэглэгддэг хиинүүдэд аль нь хамаарагдах вэ ?

1. Этилений оксид
2. пропилений оксид
3. b-пропиолактон
4. полиэтиленоксид
5. пропиленгликоль

/124./ Үрэлд ямар зорилгоор туслах бодисуудыг нэмдэг вэ?

1. үрэл эмэнд жин багтаамж олгох зорилгоор
2. үрэлд уян хатан байдал олгох зорилгоор
3. үрэлд хэлбэр дүрс олгох зорилгоор
4. үрэл эмийн бүрэлдэхүүнд орж байгаа эмийн бодисын үйлчилгээг ихэсгэх зорилгоор
5. үрэл эмийн бүрэлдэхүүнд орж байгаа эмийн бодисын үйлчилгээг хурдасгах зорилгоор

/125./ Амархан исэлддэг бодисын уусмалын тогтворжуулахад хэрэглэгддэг бодисыг заах

1. Вейбелийн тогтворжуулагч
2. Давсны хүчил
3. Этилендиаминтетра-цууны хүчил
4. Натрийн шүлт
5. Натрийн гидрокарбонат

/126./ Тосон түрхэцээс эмийн бодис шимэгдэх процессыг сайжруулах сууринд ямар суурь хамаарагддаг вэ?

1. Вазелин
2. Ланолин ургамлын тостой холимог
3. Силиконон суурь
4. Константны эмульсэн суурь ус/ вазелин
5. Загасан тос

/127./ Хөвмөлийн тогтвортой чанар нь дараах хэмжигдэхүүний аль алинтай нь урвуу пропорциональ хамааралтай вэ?

1. Жижиг хэсгийн диаметртай
2. Хүндийн хүчний хурдатгалтай
3. Дисперсийн орчин ба дисперсийн фазын нягтын ялгавартай
4. Орчны зуурамтгай чанартай
5. Дисперсийн фазын шинж чанар

/128./ Дараах ямар тохиолдолд конденсацын арга нь хөвмөл эмийн хэлбэрийг бэлтгэхэд хэрэглэгддэг вэ?

1. Дисперсийн орчинд эмийн бодис нь уусахгүй тохиолдолд
2. Уусгагчийг солих
3. Уусалтыг сайжруулах

4. Химийн урвалын үр дүнд тунадас үүсэх

5. Коалесценц

/129./ Идээшмэл чанамалын тунг хэрхэн шалгах вэ?

1. Нэг удаагийн тунг олохдоо түүхий эдийн хэмжээг шингэн эмийг хэдэн удаа хэрэглэх тоонд харьцуулж гаргана.

2. Хоногийн тунг шалгахдаа 1 удаагийн тунг хоногт хэрэглэх тоогоор үржүүлнэ

3. Фармакопейн заалттай харьцуулж үзнэ.

4. Нэг удаагийн тунг олохдоо бэлдэх ялгамлын нийт эзэлхүүнийг эмийг хэдэн удаа хэрэглэх тоонд харьцуулж гаргана.

5. Хоногийн тунг шалгахдаа түүхий эдийн хэмжээг хэдэн удаа хэрэглэх тоогоор үржүүлнэ

/130./ Хөвмөлийн шинж чанарыг нэрлэнэ үү?

1. Гадна байдал нь тунгалаг

2. Жижиг хэсгүүд нь ультра шүүлтүүрээр нэвтэрэхгүй.

3. Жижиг хэсгүүд нь цаасан шүүлтүүрээр нэвтэрнэ.

4. Гэрлийг ойлгож, хугалсны дүнд сарниулна

5. ердийн микроскопд харагдахгүй.

/131./ Гомоген тосон түрхэцэд ямар тосон түрхэцүүд хамаарагдах вэ?

1. эмульс хэлбэрийн тосон түрхэц

2. хайлш хэлбэрийн тосон түрхэц

3. экстракционы тосон түрхэц

4. уусмал хэлбэрийн тосон түрхэц

5. хосолсон хэлбэрийн тосон түрхэц

/132./ Коллоид уусмалын шинж чанарыг нэрлэнэ үү?

1. Гадна байдал нь тунгалаг\солонгорсон\

2. Жижиг хэсгүүд нь цаасан шүүлтүүрээр нэвтэрнэ.

3. Жижиг хэсгүүд нь цаасан шүүлтүүрээр нэвтэрнэ.

4. Жижиг хэсгүүд нь мембранаар нэвтрэхгүй

5. Харьцангуй тогтворгүй

/133./ Дараах шингэнүүдээс аль нь ус давс ба хүчил шүлтни тэнцвэрийг тохируулдаг шингэнд хамаарагдах вэ?

1. Гемодез

2. Аминопептидын уусмал

3. Реополиглюкин

4. Рингер-Локкын уусмал

5. Полиглюкин

/134./ Амархан исэлддэг бодисын уусмалыг бэлтгэхдээ

1. шууд олгох шилэнд бэлтгэнэ.

2. шилэн шүүлтүүрээр шүүнэ.

3. халуун нэрмэл усаар сайтар зайлсан хөвөнгөөр шүүнэ

4. шүүлтийн цаас хэрэглэхгүй.

5. шүүлгүйгээр олгоно

/135./ Зуурамтгай шинж чанартай уусгагч бүхий уусмалыг бэлтгэх ямар онцлог байдаг вэ?

1. Жингийн аргаар бэлтгэх

2. Ариутгасан хуурай олгох шилэнд халаах замаар уусгана.

3. Шаардлагатай бол хоёр давхар самбайгаар шүүнэ.

4. Жин-эзэлхүүний аргаар бэлтгэх

5. Халаах шаардлага гардаг учир хуурай шилэнд уусгана.

/136./ Нунтаг эмийн хэлбэрийн давуу талд аль нь хамаарагдах вэ?

1. жижиглэлтийг зохицуулах боломжтой

2. туслах бодисгүй

3. биологийн үйлчилгээ сайн

4. технологи нь энгийн

5. кристалл бүтцээрээ байгаа эмүүд

/137./ Өндөр молекулт нэгдэл ба хамгаалагдсан коллойд уусмалыг бэлтгэхэд тэдгээрийн хоёуланд нь байдаг ямар нийтлэг шинж чанарыг тооцох шаардлагатай вэ?

1. Молекулын хэмжээ том байдаг
2. Электролит сөргөөр нөлөөлдөг
3. Дисперсийн системийн төрөл
4. Диффузын хурд бага
5. Зуурамтгай чанар нь өндөр байдаг.

/138./ Тосон түрхэцийн чанарын шалгуурт аль нь хамаарагдах вэ?

1. Бүрэн деформацид орох хугацаа
2. Нэгэн төрөл байх
3. Хуурай үлдэгдэл
4. Эмийн бодисын жижиг хэсгийн хэмжээ
5. Зуурамтгай чанар

/139./ Нийлмэл найрлагатай эмийн бэлдмэлийг бэлтгэхэд үүсч болох физик химийн ба химийн зохисгүй процессууд нь ямар шалтгааны дүнд бий болдог вэ?

1. жорон дахь ингредиентүүдийн тоон харьцаагаар
2. фармакологийн антогонизмаар
3. орчны pH- аар
4. бэлтгэх аргаар
5. Орчны зуурамтгай чанараас

/140./ Хүчтэй суурь, сул хүчлийн үлдэгдлээс тогтсон эмийн бодисыг тогтворжуулахад хэрэглэгддэг бодисыг заах

1. Давсны хүчил
2. Натрийн шүлт
3. Вейбелийн тогтворжуулагч
4. Натрийн гидрокарбонат
5. Этилендиаминтетра-цууны хүчил

/141./ Хуурай халуун агаараар ямар зүйлүүдийг ариутгаж болох вэ ?

1. Металл, шил, шаазан эдлэл
2. Халуунд тэсвэртэй нунтаг эмийн бодисууд
3. Эрдсийн ба ургамлын тос, ланолин, вазелин, лав
4. Өндөр температурт тогтвортой бодисын уусмал
5. хөвөн, самбай, шүүлтийн цаас, үйсэн ба резинэн бөглөө, пергаментэн цаас,

/142./ Ургамлын түүхий эдээс усан ялгамал бэлтгэхэд ямар шинж чанарыг тооцох ёстой вэ?

1. Түүхий эдийн эсийн бүтэц
2. Үйлчлэгч бодисын физик химийн шинж чанар
3. Дагалдагч болон балласт бодисын физик химийн шинж чанар
4. Шүүх арга
5. Экстрагентын эзэлхүүн

/143./ Фармакопейн заалтын дагуу лааны чанарыг ямар шалгуураар шалгадаг вэ?

1. Уусах хугацаа
2. Нэгэн төрөл
3. Задралт
4. Деформацид бүрэн орох хугацаа
5. Лааны жингийн хэлбэлзэл

/144./ Жоронд эмийн бодисын тун хэтэрсэн тохиолдолд яах вэ?

1. Тусгай тэмдэглэл байвал бэлтгэж болно.
2. Эмийн бодисын нэг удаагийн дээд тунгийн хагасыг олгоно.
3. Мансууруулах бодисын эмийн тунгийн тоог багасгаж олгох нормоос нийлбэр тун нь ихгүй байхаар олгоно.
4. Жорыг олгохгүй.
5. Эмчтэй нь зөвлөж шийднэ.

/145./ Хэрэв жоронд тосон түрхэцийн суурийг заагаагүй ба техникийн баримт бичигт тосон түрхэцийн найрлага нь байхгүй байх тохиолдолд суурийг сонгож авахдаа юуг тооцох ёстой вэ?

1. Тосон түрхэцийн хэрэглэх зориулалтаар
  2. Дисперсийн системийн төрөл
  3. Эмийн бодисуудын физик химийн шинж чанар
  4. Эмийн бодисын хэмжээ
  5. Эмийн бодисын усанд уусах чанар
- /146./ Цийдмэгийн тогтвортой чанарыг шалгахад:
1. 3 хоног хадгалахад үелж салах ёсгүй
  2. Минутанд 1500 удаа эргэх центрифугт хийхэд үелж салах ёсгүй.
  3. Минутанд 1000 удаа эргэх центрифугт хийхэд үелж салах ёсгүй.
  4. 50 С хүртэл халаахад үелж салах ёсгүй.
  5. 30 С хүртэл халаахад үелж салах ёсгүй
- /147./ Хордлого тайлах шингэнд дараах шингэнүүдээс аль нь хамаарагдах вэ?
1. рингер локкийн уусмал
  2. гемодез
  3. аминопептидийн уусмал
  4. полидез
  5. реополиглюкин
- /148./ Хөвмөлийн шинж чанарыг нэрлэнэ үү?
1. Гадна байдал нь тунгалаг
  2. Жижиг хэсгүүд нь ультра шүүлтүүрээр нэвтэрэхгүй.
  3. Жижиг хэсгүүд нь цаасан шүүлтүүрээр нэвтэрнэ.
  4. Гэрлийг ойлгож, хугалсны дүнд сарниулна
  5. ердийн микроскопд харагдахгүй.
- /149./ Тосон уусмалыг тогтворжуулахад хэрэглэгддэг бодисыг заах
1.  $\text{Na}_2\text{SO}_3$
  2. Бутилокситолуол
  3. Мерказолил
  4. а-токоферол
  5. Тиомочевин
- /150./ Тритурацийг бэлтгэхэд туслах чанарын бодисоор яагаад сүүний сахарыг авдаг вэ?
1. Сүүний сахар нь хувийн жингээрээ ихэнх алкалоидын давстай ойролцоо /1.52/
  2. Чийг татахгүй
  3. Бэлтгэсэн холимог задрахгүй
  4. Тун алдагдах тал гарахгүй
  5. Удаан хадгалахад ч ялгардаггүй
- /151./ Удаан уусдаг бодисын уусмалыг бэлтгэхдээ дараах аргуудаас алийг нь хэрэглэдэг вэ?
1. эмийн бодисыг жижиглэх
  2. уусгах
  3. халаах
  4. хутгах
  5. дэвтээх
- /152./ Усан ба спиртен уусмал бэлтгэх ерөнхий технологийн дүрмэнд аль арга нь хамаарах вэ?
1. Жин эзэлхүүний арга
  2. Халаах, шүүх
  3. Уусгагчийг эзэлхүүнээр хэмжиж авах арга
  4. Эмийн бодисыг жигнэж авсныхаа дараа уусгагчийг нэмэх
  5. Хуурай ариутгасан шилэнд уусгах процессыг явуулна.
- /153./ Эмульсийн тогтвортой байдалд нөлөөлөх хүчин зүйлүүдэд аль нь хамаарагдах вэ?
1. дисперсийн фазын хэмжээ
  2. Дисперсийн фаз ба орчны нягтын ялгаатай байдал
  3. Фазуудын хоорондох таталцлын хүч
  4. Дисперсийн орчны консистенц
  5. эмульсжүүлэгч

- /154./ Жин –эзэлхүүний аргаар ямар уусмалуудыг бэлтгэдэг вэ?
1. Усан уусмал
  2. Спиртэн уусмал
  3. Коллойд уусмал
  4. Тосон уусмал
  5. Жоронд уламжлалт нэрээр бичигдсэн стандарт шингэн
- /155./ Урсгал уураар ус, усан уусмалыг эзэлхүүнээс нь хамааруулан хэрхэн ариутгадаг вэ ?
1. 100 мл хүртэл хэмжээтэй бол 30 мин ариутгана
  2. 101-500 мл бол 45 мин ариутгана
  3. 501-1000 мл бол 60 мин ариутгана
  4. 1001-1500 мл бол 75 мин ариутгана.
  5. 1500 мл-ээс дээш бол 90 мин ариутгана
- /156./ Эмийн сангийн нөхцөлд тарилгын уусмал бэлтгэх технологт аль нь хамаарах вэ?
1. Эмийн бодисыг уусгаж уусмал бэлтгэх
  2. Уусмалыг шүүж, механик хольцыг шалгах
  3. Шилийг бөглөж хаяглах
  4. Уусмалыг ариутгах
  5. Уусмалын чанарыг шалгаж бэлэн болгох
- /157./ Лаа эмийн хэлбэрт тавигдах шалгууруудад аль нь хамаарагдах вэ?
1. ердийн температурт хатуу байдалтай.
  2. хүний биеийн температурт хайлдаг
  3. эмийн бодисыг хурдан чөлөөлдөг байх ёстой
  4. хурдан хайлж салст бүрхэвчээр жигд тархдаг.
  5. салст бүрхэвчийг цочроох нөлөө үзүүлдэггүй.
- /158./ Ургамлын түүхий эдээс үйлчлэгч бодисыг бүрэн гүйцэд хандлахад юу нөлөөлдөг вэ?
1. Түүхий эд экстрагентын харьцаа
  2. Диффузын процессын хурд
  3. Хандлах дэглэм
  4. Усан ялгамлын эзэлхүүн
  5. Экстракт-концентратын эзэлхүүн
- /159./ Лааны сууринд тосон түрхэцийн сууриас ялгагдах ямар өвөрмөц шаардлагууд тавигддаг вэ?
1. Биеийн температурт уусдаг
  2. Биеийн температурт хайлдаг.
  3. Тасалгааны температурт хатуу
  4. Эмийн бодисыг хурдан чөлөөлдөг
  5. Зөөлөн консестенцтэй байх
- /160./ Тун шилтэй уусмалыг шалгах шалгуур үзүүлэлтэнд аль нь хамаарагдах вэ? Зөв хариултыг сонгоно уу?
1. Туншилний бүрэн бүтэн байдал
  2. Уусмалын рН-г тодорхойлох
  3. Уусмалын дүүргэлт
  4. Уусмалын даралтыг шалгах
  5. Туншилний хайлах температурыг шалгах
- /161./ Уусах процессыг хурдасгахад ямар үйлдлийг хийж болох вэ? Зөв хариултыг сонгоно уу?
1. Уусдаг давс үүсгэх
  2. Халаах
  3. Урьдчилан жижиглэх
  4. Уусгагчийг хөдөлгөөнд оруулах
  5. Комплекс нэгдэл үүсгэх
- /162./ Ямар тохиолдолд хэвлэх аргаар шахмалыг гарган авдаг вэ? Зөв хариултыг сонгоно уу?
1. Эмийн бодисын туналалт маш бага байх тохиолдолд туслах бодисыг бага хэмжээгээр нэмэх үед

2. Уусмал бэлтгэх зориулалтын шахмал хийх тохиолдолд
  3. Далалтын нөлөөгөөр эмийн бодис нь ямар нэгэн өөрчлөлтөнд орох үед
  4. Шахмал хийх масс нь чийг их татдаг байвал
  5. Шахмал хийх масс нь шахмал болохгүй бутрах эсвэл бат бэх биш шахмал үүсгэх үед
- /163./ Тун шилний дотор талыг ямар аргаар угаадаг вэ? Зөв хариултыг сонгоно уу?
1. Вакуумын арга
  2. Хэт авианы тусламжтайгаар
  3. Тариурын аргаар
  4. Химийн аргаар
  5. Конденсацын арга
- /164./ Хатуу капсулд ямар эмийг туналаж хийдэг вэ? Зөв хариултыг сонгоно уу?
1. Ургамлын хуурай ханд
  2. Нунтаг
  3. Мөхлөг
  4. микрогранул
  5. Паст
- /165./ Шахмал эмэнд яагаад бүрхүүл тавих шаардлага гардаг вэ? Зөв хариултыг сонгоно уу?
1. Эмийн бодисын эвгүй үнэр амт зэргийг далдлах зорилгоор
  2. Эмийн бодисын үйлдлийг хоол боловсруулах эрхтэн системийн аль нэгэн тодорхой хэсэгт үзүүлэх зорилгоор
  3. Агаар, чийг, гэрэл зэрэг гадны хүчин зүйлд өртөхөөс сэргийлэх зорилгоор
  4. Зарим эмийн бодис нь ходоод гэдэсний салстыг цочроох үйлдэлтэй байдаг учир түүнээс зайлсхийхийн тулд
  5. Шахмал эмийн гадаад өнгө үзэмжийг сайжруулах зорилгоор
- /166./ Гоюу хийх үндсэн түүхий эд нь юу вэ? Зөв хариултыг сонгоно уу?
1. Давирхай
  2. парафин ланолин вазелин
  3. өөх тос өөхний дээд хүчлийн давснууд
  4. каучук
  5. дэгдэмтгий уусгагчид
- /167./ Ариутгасан тарилгын нэрмэл усыг гарган авахдаа халууруулах бодис оруулахгүйн тулд ямар зарчим баримтлах вэ? Зөв хариултыг сонгоно уу?
1. Ууршуулах тогоонд түүний багтаамжын 2/3-аас ихгүй хэмжээний усаар дүүргэх
  2. Хөргөгчийг буцалгагч цахилгаан халаагуураас нь аль болох хол байрлуулах
  3. Нэрэх тогоонд дотор уур дамжих хоолойны өргөн хэсэгт зэвэрдэггүй гангаар хийгдсэн ялгах сараалжыг байрлуулах
  4. Усыг өндөр даралт температурын дор буцалгах
  5. Ууршуулах тогоонд түүний багтаамжийн 1/3-ээс ихгүй хэмжээтэй ус дүүргэх
- /168./ Шахмалыг нарийн зөв туналах үйл ажиллагаанд ямар ямар хүчин зүйл нөлөөлөх вэ? Зөв хариултыг сонгоно уу?
1. Матрицын нүхний эзэлхүүн тогтмол байх, өөрөөр хэлбэл доод пуансоны байрлал нэг түвшинд байх
  2. Матрицын нүхийг шахмалын массаар жигд тасралтгүй дүүргэх
  3. Шахмал хийх массын фракцын бүрэлдэхүүн нэгэн төрлийн байх
  4. Үрэлтийг багасгах зорилгоор гулсуулах бодис нэмэх
  5. Холбогч бодисыг нэмэх.
- /169./ Шахмал эмэнд сахаран бүрхүүл тавих технологийн үе шатанд аль нь хамаарагдах вэ? Зөв хариултыг сонгоно уу?
1. Хөрсжүүлэх
  2. Бүрэх
  3. Толийлгох
  4. Өнгөлөх
  5. Томруулах
- /170./ Шигших процесст нөлөөлөх хүчин зүйлүүд юу вэ? Зөв хариултыг сонгоно уу?

1. Шигшүүрийн нүхний хэлбэр хэмжээ
2. Шигшигдэж байгаа материалын үений зузаан
3. Шигшигдэж байгаа материалын чийглэг
4. Шигшигдэж байгаа материалын хөдөлгөөний хурд
5. Шигшүүрийн хөдөлгөөний чиглэл

/171./ Нунтагийн урсах чанар юунаас хамаарах вэ? Зөв хариултыг сонгоно уу?

1. Нунтагийн жижиг хэсгийн хэмжээнээс
2. Жижиг хэсгүүдийн хэлбэрээс
3. Нунтагийн чийглэгээс
4. Нунтагийн механик хольцоос
5. Нунтагийн хувийн гадаргуугаас

/172./ Хатуу болон зөөлөн капсулыг ямар аргаар гарган авдаг вэ?. Зөв хариултыг сонгоно уу?

1. Дүрэх арга
2. Дуслын арга
3. Хэвлэх
4. Хөөлгөх
5. Өнхрүүлэх

/173./ Тарилгын эмийн хэлбэрийг ямар аргаар ариутгах вэ? Зөв хариултыг сонгоно уу?

1. Химийн
2. Физикийн
3. Механик
4. Бактеростатик
5. Хэт ягаан туяагаар

/174./ Агшимтгай уян шүүлтүүрт аль нь хамаарагдах вэ? Зөв хариултыг сонгоно уу?

1. Шаазан шүүлтүүр
2. Зэвэрдэггүй гангаар хийгдсэн шүүлтүүр
3. Металл шүүлтүүр
4. Даавуун шүүлтүүр
5. Шилэн шүүлтүүр

/175./ Горчичник үйлдвэрлэх технологийн процессын үе шатанд аль нь хамаарагдах вэ? Зөв хариултыг сонгоно уу?

1. Каучукийн цавуу бэлтгэх
2. Гичийн гоюуны массыг гарган авч каучукийн цавуутай холих
3. Массыг цаасан дээр түрхэж хатааж зүсэх
4. Тосон суурийг хайлуулах гоюуны массанд оруулах
5. Тосон суурийг жигдрүүлэх

/176./ Янз бүрийн фракцын бүрэлдэхүүнтэй нунтаг эмийн бодисыг салгахдаа ямар аргаар явуулдаг вэ? Зөв хариултыг сонгоно уу?

1. Механик аргаар
2. Усанд тунадасжих хурдаар
3. Агаарт тунадасжих хурдаар
4. Электрлитийн аргаар
5. Химийн урвалын хурдаар

/177./ Хүүхдийн эмчилгээний лаанд ямар үйлдэлтэй бодисыг оруулдаггүй вэ? Зөв хариултыг сонгоно уу?

1. Үрэвсэл намдаах
2. Булчин татах үйлдлийг сулруулах
3. Туулгах үйлдэлтэй
4. Хортой хүчтэй үйлдэл бүхий эмийн бодис
5. Халуун бууруулах

/178./ Шингэн орчноос хатуу фазыг ямар аргуудаар ялгаж болдог вэ? Зөв хариултыг сонгоно уу?

1. Тунгаах
2. Хурилтуурдах



3. Шүүх
4. Халаах
5. Буцалгах

/179./ Аскорбины хүчлийн 50мг үрэл эмийг үйлдвэрлэхдээ үйлчлэгч бодисоор бүрсний дараа ямар хэмжээтэй шигшүүрээр шигшдэг вэ? Зөв хариултыг сонгоно уу?

1. 4.0-5,5мм
2. 4.0-5.5мм
3. 4,0-5,0мм
4. 4,0-4,5мм
5. 5,5-6.0мм

/180./ Мембранаар ялгах процессын онцлог нь юу вэ. Зөв хариултыг сонгоно уу?

1. Уусмалыг цэвэршүүлэх зорилгоор хэрэглэдэг
2. Хагас нэвтрүүлэгч мембран ашигладаг
3. Энерги зарцуулалт бага байдаг
4. Хүрээлэн буй орчны температурт явагддаг
5. Сонгомол шинж чанартай

/181./ Желатины өвөрмөц шинж чанарт юу орох вэ? Зөв хариултыг сонгоно уу?

1. Уургийн бодис агуулдаг
2. Бактер өсөх таатай нөхцөл болдог
3. Янз бүрийн бодисуудыг нэмэлт байдлаар оруулах боломжтой
4. Уусмал нь хөрөхөөрөө царцаж хатуу гель үүсгэдэг
5. Уусмал нь хөрөхөөрөө царцаж зөөлөн гель үүсгэдэг

/182./ Эмульгаторын үндсэн ангилал юу вэ? Зөв хариултыг сонгоно уу?

1. Ионогений гадаргуугын идэвхт бодис
2. Ионогений бус гадаргуугын идэвхт бодис
3. Амьтан ургамал эрдсийн гаралтай гадаргуугын идэвхт бодис
4. Усанд уусдаг
5. Усанд бага уусдаг

/183./ Ариутгах аргад аль нь хамаарагдах вэ? Зөв хариултыг сонгоно уу?

1. Вакуумын арга
2. Радиацийн арга
3. Параконденсацийн арга
4. Хийгээр ариутгах
5. Вибрацийн арга

/184./ Хийгээр ариутгах бодист аль нь хамаарах вэ? Зөв хариултыг сонгоно уу?

1. Пропилений оксид
2. Полиэтилен
3. Азотын исэл
4. Этиленоксид
5. Хлорформ

/185./ Сахарын сироп бэлтгэх технологийн үе шатанд аль нь хамаарагдах вэ?

1. Сахарыг уусгах.
2. Шүүх
3. Буцалгах
4. Хөөс хамах
5. Карамелизац үүсгэх

/186./ Тосон түрхцийг консинстенцээр юу гэж ангилах вэ? Зөв хариултыг сонгоно уу?

1. Жинхэнэ тосон түрхэц
2. Паст
3. Крем
4. Гель
5. Линимент

/187./ Вакуум ууршуулагчийн давуу тал аль нь вэ? Зөв хариултыг сонгоно уу?

1. Уусмалын буцлах температурыг ихэсгэдэг
2. Үнэтэй уусгагчийг нэрж гаргах боломжтой

3. Үйлдвэрлэлийн байранд уурыг задгай алдахад хүргэдэг
  4. Уусмалын буцлах температурыг бууруулах боломжтой
  5. Атмосферийн даралтанд ууршуулах боломжтой.
- /188./ Дротыг ямар аргаар угаах боломжтой вэ? Зөв хариултыг сонгоно уу?
1. Тасалгаат угаагч
  2. Сүмбэдэж угаах
  3. Хэт авианы тусламжтайгаар
  4. Шприцын аргаар
  5. Вакумын арга
- /189./ Желатинан капсул гаргаж авахад ямар бодисыг хэрэглэдэг вэ? Зөв хариултыг сонгоно уу?
1. Пластификатор
  2. Консервант
  3. Үнэр өнгө оруулагч бодис
  4. Хөвсийлгөгч бодис
  5. Дүүргэгч бодис
- /190./ Зөөлөн капсулд ямар эмийг тунлаж савладаг вэ? Зөв хариултыг сонгоно уу?
1. Мөхлөг
  2. Паст
  3. Нунтаг
  4. Өтгөвтөр шингэн
  5. Ургамлын түүхий эд
- /191./ Шүүлтүүрийн материалд ямар шаардлага тавьдаг вэ? Зөв хариултыг сонгоно уу?
1. Шаардлагатай хэмжээний нүхтэй байх
  2. Химийн тогтвортой байх
  3. Механик бат бөх чанартай байх
  4. Дахин ашиглах боломжтой байх
  5. Боломжийн хямд үнэтэй байх
- /192./ Ингаляцийн аэрозольд ямар уусгагчийг хэрэглэдэг вэ? Зөв хариултыг сонгоно уу?
1. Ургамлын тос
  2. Этанол
  3. Ус
  4. Этилацетат
  5. Ацетон
- /193./ Тоног төхөөрөмжийн хөдөлмөрийн бүтээмжийг ямар үзүүлэлтээр үнэлдэг вэ? Зөв хариултыг сонгоно уу?
1. Тоног төхөөрөмжийн багтаамжаар
  2. Нэгж хугацаанд үйлдвэрлэн гаргах бүтээгдэхүүнээр
  3. Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх хугацаагаар
  4. Гологдол бүтээгдэхүүний тоо хэмжээгээр
  5. Дагалдах бүтээгдэхүүний тоо хэмжээгээр
- /194./ Пропеллент бодисыг агрегат байдлаар нь хэрхэн ангилах вэ? Зөв хариултыг сонгоно уу?
1. Шингэрүүлсэн хий
  2. Шахсан хий
  3. Амархан дэгддэг органик уусгагч
  4. Шингэн уусмал
  5. Шингэрүүлсэн уусмал
- /195./ Үйлдвэрлэлийн байрыг ямар ямар бүс болгон хувааж үздэг вэ? Зөв хариултыг сонгоно уу?
1. Цагаан бүс
  2. Саарал бүс
  3. Хар бүс
  4. Ногоон бүс
  5. Цэнхэр бүс

/196./ Агаарын хийн урсгалын тусламжтайгаар нунтаглагч тээрмийн ажиллагаанд аль нь хамаарагдах вэ? Зөв хариултыг сонгоно уу?

1. Жижиглэлтийг холих, хатаах процесстой хамт явуулах боломжтой
2. Маш нарийн коллойд нунтаг гарган авах боломжтой
3. Агаарын урсгалын дэглэмийг нарийн чанд баримтлах шаардлагатай.
4. Бэлэн бүтээгдэхүүн нь нунтаглагчийн эд ангиас үүсэлтэй зүйлээр бохирддоггүй сайн талтай.
5. Энерги их зарцуулдаг.

/197./ Шахмал эмийн хэлбэрийн давуу талд аль нь орох вэ? Зөв хариултыг сонгоно уу?

1. Хадгалах явцад задралт нь удааширдаг.
2. Хадгалах явцад хатуурч цемент шиг болдог.
3. Бүх өвчтөнгүүдэд хэрэглэж чаддаггүй
4. Нарийн туналагдсан
5. Концентрацтай уусмал үүсч салстыг цочроодог.

/198./ Каучукан гоюу үйлдвэрлэх технологийн процессын үе шатанд аль нь хамаарагдах вэ? Зөв хариултыг сонгоно уу?

1. Гоюуны массыг даавуун материал дээр түрхэж, хатаах
2. Ороох, зүсэх ба чанарыг нь шалгах
3. Савлах
4. Цаасан дээр массыг жигд түрхэх
5. Хэлбэржүүлэх

/199./ Хатуу биетийг жижиглэдэг тоног төхөөрөмжийг зөв сонгохдоо дараах үзүүлэлтээс алийг нь илүүд үзэх вэ? Зөв хариултыг сонгоно уу?

1. Материалыг жижиглэх арга
2. Тоног төхөөрөмжийн ажиллах зарчим
3. Материалын жижиглэгдсэн байдал
4. Машины овор хэмжээ
5. Машины эд ангийн бүтэц

/200./ Үрэл эмийн хэлбэрийг өнгөлөхөд ямар бодис ордог вэ? Зөв хариултыг сонгоно уу?

1. Тальк
2. Лав
3. Ургамлын тос
4. Сахарын пудр
5. Метилцеллюлоз

/201./ Хурилтуурдах арга нь ямар зарчимд үндэслэгддэг вэ? Зөв хариултыг сонгоно уу?

1. Хагас нэвтрүүлэгч мембраны үйлчлэлээр
2. Хүндийн хүч болон инерцийн хүчний үйлчлэлээр
3. Даралтын хүчний нөлөөгөөр
4. Төвөөс зугтах хүчний үйлчлэлээр
5. Төв үү чиглэлтэй хүчний нөлөөгөөр

/202./ Олон үет шахмалын давуу тал нь юу вэ? Зөв хариултыг сонгоно уу?

1. Үл нийцдэг эмийн бодисуудыг нэг эмийн хэлбэрт оруулах боломжтой
2. Эмийн бодисын үйлчилгээг удаашруулах
3. Эмийн бодисын шимэгдэлтийг зохицуулах
4. Усанд уусдаг болон уусдаггүй туслах бодисыг агуулдаг
5. Эмийн бодисын үйлчилгээг хурдасгадаг

/203./ Аэрозоль үйлдвэрлэх технологийн процессийн үе шатанд аль нь хамаарагдах вэ? Зөв хариултыг сонгоно уу?

1. эмийн бодис ба туслах бодисын концентратыг бэлтгэх
2. пропеллентын холимог бэлтгэх
3. баллоныг дүүргэх ба түүний чанарыг шалгах
4. ариутгах
5. холимогийг нэгэн төрлийн болгож жигдрүүлэх

/204./ Хийгээр ариутгасан бодисуудыг ариутгалын бодисоос хэрхэн цэвэрлэх вэ? Зөв хариултыг сонгоно уу?

1. Уураар үйлчилнэ
2. Агааржуулах
3. Тусгай бодис ашиглан салгана
4. Вакуум орчин бий болгоно
5. Хлорформд шингээж ялгана

/205./ Микрокапсулыг ямар аргуудаар гаргадаг вэ? Зөв хариултыг сонгоно уу?

1. Коацервацын аргаар
2. Тоосруулан хатаах аргаар
3. Поликонденсацын аргаар
4. Дүрэх аргаар
5. Хэвлэх аргаар

/206./ Ямар шалтгааны улмаас эмийн бодисыг микрокапсул эмийн хэлбэрт оруулдаг вэ? Зөв хариултыг сонгоно уу?

1. Хий болон шингэн байдалтай эмийн бодисыг хуурамч хатуу байдалд оруулах
2. Тогтвор муутай эмийн бодисыг гадны хүчин зүйлээс хамгаалах
3. Эмийн бодисын цочроох болон гаж үйлдлийг багасгах
4. Эмийн бодисын үйлдлийг ходоодны хүчиллэг орчноос хамгаалах
5. Туулгах зорилготой

/207./ Тосон түрхлэгийг яаж стандартчлах вэ? Зөв хариултыг сонгоно уу?

1. Нэгэн төрөл байдал
2. Тосон түрхцийн консистенц буюу бүтцийн механик чанар
3. Агуулагдах бодисын тоон үзүүлэлт
4. Хадгалах явцад тогтвортой байх чанар
5. Эмийн хэлбэрээс эмийн бодис чөлөөлөгдөх хугацаа

/208./ Туншилийг ямар аргаар гагнадаг арга? Зөв хариултыг сонгоно уу?

1. Вакумын арга
2. Хайлуулж гагнах арга
3. Дулааны арга
4. Сунгаж гагнах арга
5. Зүсж гагнах арга

/209./ Зөөлөн капсулд ямар консистенцтэй эмийн бодисыг дүүргэдэг вэ? Зөв хариултыг сонгоно уу?

1. Өтгөвтөр шингэн
2. Шингэн
3. Паст
4. Өтгөн
5. Зуурамтгай

/210./ Шууд шахах аргаар шахмал эм гарган авахад нунтаг эмийн бодис нь ямар шинж чанартай байх ёстой вэ? Зөв хариултыг сонгоно уу?

1. Урсах чанар сайтай
2. Шахагдах чанар сайтай
3. Тодорхой чийглэгтэй байх
4. Асгарах жин сайтай байх
5. Фракцын бүрэлдэхүүн сайтай байх

/211./ Ингаляцийн аэрозольд ямар уусгагчийг хэрэглэдэг вэ? Зөв хариултыг сонгоно уу?

1. Ургамлын тос
2. Этанол
3. Ус
4. Этилацетат
5. Ацетон

/212./ Бүтээгдэхүүний материалын орцыг зохиоход ямар үзүүлэлтүүдийг гол үзүүлэлт болгон авах бэ? Зөв хариултыг сонгоно уу?

1. Үйлдвэрийн алдагдал
2. Бэлэн бүтээгдэхүүний хэмжээ
3. Хаягдал бүтээгдэхүүний хэмжээ

4. Эхлэл материалын хэмжээ
5. Дагалдах бүтээгдэхүүний хэмжээ

/213./ Лааг ямар шалгуураар стандартчилдаг вэ? Зөв хариултыг сонгоно уу?

1. Хайлах температур тодорхойлох
2. Эмийн бодисын тоон хэмжээг тодорхойлох
3. Механик бат бэх чанар
4. Деформацад бүрэн орох хугацаа
5. Уусах хугацаа

/214./ Хатаах процессыг явуулахад сүүлийн үед ямар аргуудыг хэрэглэж байна вэ? Зөв хариултыг сонгоно уу?

1. Хатаах шүүгээнд
2. Өндөр давтамжтай цахилгаан гүйдэл
3. Тасалгааны температурт хатаах
4. Гүн вакуумын дор хөлдөөх
5. Өндөр даралтын дор хатаах

/215./ Дараах үзүүлэлтүүдээс аль нь шахмал хийх мөхлөгийн чанарыг илэрхийлж чадах вэ? Зөв хариултыг сонгоно уу?

1. Мөхлөгийн фракцын бүрэлдэхүүн
2. Мөхлөгийн чийглэг
3. Мөхлөгийн шахагдах чанар
4. Мөхлөгийн дундаж жин түүний хэлбэлзэл
5. Мөхлөгийн алдагдал

/216./ Тосон уусмалыг тогтворжуулахад хэрэглэдэг тосонд уусдаг антиоксидант бодис аль нь бэ? Зөв хариултыг сонгоно уу?

1. Натрийн метабисульфит
2. Бутилокситолуол
3. Мерказолил
4. а-токоферол
5. Тиомочевин

/217./ Матрицын нүх нь шахмал хийх массаар жигд дүүргэгдэх нь технологийн ямар шинж чанараас хамаарах вэ? Зөв хариултыг сонгоно уу?

1. Матрицын нүхнээс шахмал түлхэгдэн гарах хүч
2. Фракцын бүрэлдэхүүн
3. Норгогдох чанар
4. Урсах чанар
5. Шахагдах чадвар

/218./ Хүний биеийн температурт зөөлөрч арьсанд наалдаж эмчилгээний үйлдэл үзүүлэх чадвартай гадуур хэрэглэдэг зөөлөн эмийн хэлбэрийг юу гэж нэрлэдэг вэ? Зөв хариултыг сонгоно уу?

1. Тосон түрхлэг
2. Гоюу
3. Лаа
4. Арьсны эмчилгээний идэвхт систем
5. Аэрозоль

/219./ Зэхмэл эмийн хэлбэрийн дутагдалтай талд аль нь орох вэ? Зөв хариултыг сонгоно уу?

1. Үнэ хямд
2. Боловсронгуй бус эмийн хэлбэр
3. Технолог нь маш энгийн
4. Тугнагдаагүй эмийн хэлбэр
5. Бэлтгэхэд хялбар

/220./ Тиндалийн аргаар тарилгын нэрмэл усыг ариутгахад температурын ямар дэглэм баримтлах вэ? Зөв хариултыг сонгоно уу?

1. 60-650C
2. 119-1210C

3. 70-800С
4. 80-950С
5. 15-210С

/221./ Шууд шахах аргын давуу тал аль нь вэ? Зөв хариултыг сонгоно уу?

1. Чийгтэй мөхлөгжүүлэх аргатай харьцуулбал 3-4 дамжлагыг хэмнэнэ
2. Шахмал эм үйлдвэрлэх хугацааг богиносгодог
3. Шахмалын өртөг багасна
4. Эмийн бодис чийг дулааны нөлөөнд өртдөггүй
5. Үйлдвэрлэлийн талбай, тоног төхөөрөмж, цахилгаан, ажиллах хүчийг хэмнэдэг

/222./ Капсулыг үйлдвэрлэх, эмийн бодисоор дүүргэх үйл ажиллагаа хамтдаа явагддаг ямар арга байдаг вэ?. Зөв хариултыг сонгоно уу?

1. Дүрэх
2. Хэвлэх арга
3. Хөөлгөх арга
4. Дуслын арга
5. Өнхрүүлэх арга

/223./ Аэрозолыг ямар шалгуураар шалгах вэ? Зөв хариултыг сонгоно уу?

1. Баллоны бат бөх чанарыг шалгана.
2. Баллоны массыг жигнэж шалгана.
3. Баллоноос шүршигдэн гарах бэлдмэлийн хэмжээг тодорхойлох.
4. Баллоноос шүршигдэн гарах холимогийг шахах чанарыг
5. Баллоны бин битүү байдлыг шалгана

/224./ Тунгаах процессыг тодорхойлдог үндсэн параметрууд юу вэ?

1. Жижиг хэсгүүдийн тунадасжих хурд
2. Шингэний урсгалын шугаман хурд
3. Нэгэн төрлийн бус системийн тунгаагч аппаратанд байх хугацаа
4. Жижиг хэсгийн гадаргуугийн таталцал
5. Шингэний зуурамтгай чанар

/225./ Үрлийн чанарын шалгуур үзүүлэлтэнд аль нь хамаарагдах вэ? Зөв хариултыг сонгоно уу?

1. Гадна байдал
2. Дундаж жин түүний хэлбэлзлэл
3. Задралт
4. Агуулагдах эмийн бодисыг тодорхойлох
5. Уусал

/226./ Тосон түрхэц шалгах шалгуур үзүүлэлтэнд аль нь хамаарагдах вэ? Зөв хариултыг сонгоно уу?

1. Гадна байдал, хаяглалт
2. Тосон түрхэцийн рН
3. Тосон түрхэцийн нэгэн төрөл байдал
4. Тосон түрхэцийн дисперсын фазын хэмжээ/хөвмөл хэлбэрийн тосон түрэгц байвал/-г тодорхойлох
5. Тосон түрхэцийн тогтвортой байдлыг тодорхойлох

/227./ Хатуу капсулд ямар эмийг туналаж хийдэг вэ? Зөв хариултыг сонгоно уу?

1. Ургамлын хуурай ханд
2. Нунтаг
3. Мөхлөг
4. микрогранул
5. Паст

/228./ Ямар тохиолдолд шахмалд шахах аргаар бүрхүүл тавьдаг вэ? Зөв хариултыг сонгоно уу?

1. Хортой хүчтэй үйлдэлтэй эмийн бодис агуулсан
2. 1. Шахмалын бүрэлдэхүүнд орсон бодисууд чийгийн нөлөөгөөр идэвхээ алддаг
3. Химийн болон физикийн өөрчлөлтэнд ордог эмийн бодис агуулсан

4. Эвгүй үнэр амттай бодис агуулсан бол
  5. Их хэмжээний туслах бодис агуулсан бол
- /229./ Нунтаг эмийн бодисын технологийн шинж чанарт аль нь хамаарагдах вэ? Зөв хариултыг сонгоно уу?
1. Нунтаг эмийн бодисуудын жижиг хэсгүүдийн хэлбэр, хэмжээ
  2. Фракцийн бүрэлдэхүүн
  3. Нунтагийн норгогдох чадвар
  4. Асгарах жин
  5. Нунтагийн хувийн гадаргуу
- /230./ Нунтаг эмийн бодисын технологийн шинж чанарт аль нь хамаарагдах вэ? Зөв хариултыг сонгоно уу?
1. Фракцын бүрэлдэхүүн
  2. Асгарах жин
  3. Урсах чанар
  4. Чийглэг
  5. Нунтагийн хувийн жин
- /231./ Чийгтэй мөхлөгжүүлэх уламжлалт аргаар мөхлөг хийх технологийн үе шатанд аль нь хамаарагдах вэ? Зөв хариултыг сонгоно уу?
1. Эхлэл материалыг хэмжин авч холих
  2. Нойтон мөхлөгжүүлэх
  3. Хуурай мөхлөгжүүлж, пудрдэх
  4. Чанарыг шалгах
  5. Шахах
- /232./ Дротыг ямар аргаар угаадаг вэ? Зөв хариултыг сонгоно уу?
1. Вакуумын арга
  2. Тасалгаат угаагчаар угаах
  3. Параконденсацын арга
  4. Хэт авианы тусламжтайгаар угаах
  5. Шприцын арга
- /233./ Булт шахмалын машинд дараах үндсэн хэсгүүдээс аль хэсэг нь байдаг вэ? Зөв хариултыг сонгоно уу?
1. Дүүргэх гоожуур
  2. Доод, дээд пуансон
  3. Чиглүүлэгч роликууд
  4. Давших хөдөлгөөн бүхий гүйцэтгэх механизм.
  5. Хувиарлагч тахир гол
- /234./ Хуурамч шингэрүүлсэн үеээр мөхлөгжүүлэхдээ ямар аппаратыг хэрэглэдэг вэ? Зөв хариултыг сонгоно уу?
1. Дисмембратор
  2. СГ-30
  3. Үрлийн тогоо
  4. СГ -60
  5. Чийгтэй мөхлөгжүүлэгч
- /235./ Түүхий эдийг хэт жижиглэхэд ямар муу талууд илрэх вэ?
1. Хандлагч шингэний нэвтрэн орох процесс муудна
  2. Гарган авсан ялгамал булингартай
  3. Хандлах процесс удааширна
  4. Түүхий эдийн экстрагенттэй хүрэлцэх талбай ихэснэ
  5. Түүхий эдийн технологийн шинж чанар сайжирна
- /236./ Шүүс үйлдвэрлэх технологийн үе шатанд аль нь хамаарагдах вэ?
1. Шүүх
  2. Шахаж шүүс гаргах
  3. Шүүсийг цэвэрлэж тогтворжуулах
  4. Диализд оруулах
  5. Адсорбцлох

/237./ Хандлах процесст нөлөөлөх хүчин зүйлийг нэрлэнэ үү.

1. Түүхий эдийн технологийн шинж чанар
2. Температурын нөлөө
3. Хандлах хугацаа
4. Хандлагч шингэний шинж чанар
5. Хандлагч шингэнийг сонгон авах

/238./ Эфирийн тосны шингээх чадварт үндэслэн ургамлаас ялгах аргыг заана уу.

1. Шахах арга
2. Усны ууртай нэрэх арга
3. Хандлах арга
4. Анфлеражийн арга
5. Динамик адсорбцын арга

/239./ Шингэн хандыг реперколяцын аргаар үйлдвэрлэхэд 3 перколятор ашигласан тохиолдолд бэлэн бүтээгдэхүүнийг хэд дэх өдрөөс эхэлж авах вэ?

1. 3 дахь өдрөөс
2. 1 дэх өдрөөс
3. 5 дахь өдрөөс
4. 4 дэх өдрөөс
5. 2 дахь өдрөөс

/240./ Эсрэг урсгалаар хандлах аргын түүхий эд экстракт 2 нь өөд өөдөөсөө хөдөлж хандлалт явуулдаг аппаратанд ямар аппарат хамаарах вэ?

1. Батарей перколятор
2. Зээрэнцэг диффузийн аппарат
3. Бөөрөнцөгт диффузийн аппарат
4. Пүрштэй сэлүүр бүхий аппарат
5. Ротор цохилтын аппарат

/241./ Хуурай ханданд агуулагдах чийглэгийн хэмжээ ямар байх ёстой вэ?

1. 1%-аас багагүй
2. 3%-аас ихгүй
3. 10%-аас багагүй
4. 5%-аас ихгүй
5. 25%-аас багагүй

/242./ Алкалоид агуулсан бэлдмэлийг үйлдвэрийн аргаар ургамлаас гарган авахдаа алкалоидыг гол төлөв ямар хэлбэрээр ялгах вэ?

1. Гликозид
2. Давс
3. Агликон
4. Суурь
5. Комплекс

/243./ Хандыг хэрхэн ангилах вэ?

1. Өтгөн ханд
2. Шингэн ханд
3. Хуурай ханд
4. Тосон ханд
5. Экстракт концентрат

/244./ Эсийн өсгөвөрийг гарган авах хатуу фазын аргын дутагдалтай тал юу вэ?

1. Ариун чанарын баталгааг хангах боломжгүй
2. Бүтээгдэхүүний гарц багатай
3. Хэт том талбайг ашиглана
4. Хэт бага талбайг ашиглана
5. Эсийн шинэ хана үүсэлт бага

/245./ Өтгөн хандны чанарыг ямар шалгууруудаар стандартчилдаг вэ?

1. Үйлчлэгч бодисын хэмжээ
2. Хүнд металлын хольцын хэмжээ
3. Гадаад байдал



4. Спиртын хэмжээ
5. Зуурамтгай чанар

/246./ Хандмалыг тунгааж цэвэрлэхэд ямар дэглэмийг баримтлах ёстой вэ?

1. 5-80С-д 12 цаг
2. 130С-ээс дээшгүй температурт 2 өдөр
3. 2-40С-д 5 өдөр
4. 80С-с дээшгүй температурт 2-3 өдөр
5. 15-200С-д 2 өдөр

/247./ Хандмал гарган авахад хэрэглэгдэх хандлагчийг заана уу.

1. Нэрмэл ус
2. Этилийн спирт
3. Шингэрүүлсэн хий
4. Ус-спиртийн холимог
5. Ургамлын тос

/248./ Хуурай ханд гаргаж авах технологийн схемд аль нь хамаарагдах вэ?

1. Хатаах ба хуурай ханд гаргаж авах
2. Стандартчилах
3. Ялгамлыг цэвэрлэх
4. Савлаж, хадгалах
5. Ялгамал гаргаж авах

/249./ Цэцгийн тос гарган авах аргыг заана уу.

1. Шахах арга
2. Усны ууртай нэрэх арга
3. Хандлах арга
4. Анфлеражийн арга
5. Динамик адсорбцын арга

/250./ Ургамлын түүхий эдээс усан ялгамал бэлтгэхэд ямар шинж чанарыг тооцох ёстой вэ?

1. Түүхий эдийн эсийн бүтэц
2. Үйлчлэгч бодисын физик химийн шинж чанар
3. Дагалдагч болон балласт бодисын физик химийн шинж чанар
4. Ургамлын жижиглэлтийн зэрэг
5. Экстрагентын эзэлхүүн

/251./ Гүн өсгөвөрийн аргыг явуулахад хэрэглэх орчин ямар бодисыг агуулсан байх нь зохимжтой вэ?

1. Калийн ион
2. Кальцийн ион
3. Мөсөн цууны хүчил
4. 2, 4-дихлорфеноксицууны хүчил
5. Борын хүчил

/252./ Реперколяцын аргад түүхий эдийг тэнцүү хэмжээгээр хувааж хийдэг ямар аргууд байдаг вэ?

1. АНУ-н ФК-н арга
2. Боссины арга
3. Германы ФК-н арга
4. Чулковын арга
5. Циркуляцын арга

/253./ Бамбайн хандмал 120 л-ийг гарган авахад түүхий эд, экстрагент хичнээнийг авах ёстой вэ / $K=1.5$ /?

1. 12 кг үндэс, 138 л экстрагент
2. 60 кг үндэс, 210 л экстрагент
3. 120 кг үндэс, 300 л экстрагент
4. 24 кг үндэс, 156 л экстрагент
5. 6 кг үндэс, 129 л экстрагент

/254./ Түүхий эдийг тэнцүү бус хэмжээгээр хувааж хийх аргыг заана уу.

1. Босины арга
2. АНУ-ын фармакопейн арга
3. Чулковын арга
4. Германы фармакопейн арга
5. Хурдавчилсан ремацерацийн арга

/255./ Биомассыг хатаасны дараа үлдэгдэл чийглэг хэдэн хувиас ихгүй байх ёстой вэ?

1. 5%
2. 25%
3. 20%
4. 12%
5. 10%

/256./ Этилийн сипиртийг хандлагч болгон хэрэглэхэд ямар давуу талтай вэ?

1. Ферментийн идэвхийг бууруулна
2. Бактери устгана
3. Уусгах чадвар сайтай
4. Дэгдэмхий
5. Фармакологийн хувьд саармаг бус

/257./ Шинэхэн ургамлын бэлдмэлийн шүүс хэлбэрийг хэрхэн ангилах вэ?

1. Өтгөрүүлсэн
2. Жинхэнэ
3. Хуурай
4. Ханд
5. Хандмал

/258./ Чихэр өвсний өтгөн ханд 100 кг-ыг бэлтгэхэд 25% хандлагдах бодис агуулсан түүхий эд хэчнээнийг авах вэ?

1. 280 кг
2. 200 кг
3. 100 кг
4. 300 кг
5. 50 кг

/259./ Мацерацыг ямар аргуудаар эрчимжүүлдэг вэ?

1. Түүхий эдийг урьдчилж норгох
2. Экстрагентыг хэсэгчилж хуваах
3. Хандлах хугацааг уртасгах
4. Экстрагентыг буцааж хандлалтанд оруулах
5. Түүхий эд, экстрагентын харьцааг өөрчлөх

/260./ Тосон хандны үйлдвэрлэлд ашиглаж болох хандлагчийг заана уу

1. Ургамлын тос
2. Метиленхлорид
3. Этанол
4. Минералын тос
5. Органик уусгагч

/261./ Шинэ галены бэлдмэл нь галены бэлдмэлээс юугаараа ялгаатай вэ?

1. Балласт бодисын гаж нөлөөг арилгасан
2. Ялгамал нь дээд зэргээр цэвэрлэгдсэн
3. Тарилгын уусмал байдлаар хэрэглэх боломжтой
4. Комплекс бодисыг агуулсан
5. Биологийн идэвхт бодисоор стандартчилсан

/262./ Шингэн хандыг үйлдвэрлэхэд ямар харьцаагаар түүхий эд, бэлэн бүтээгдэхүүнийг авах ёстой вэ?

1. 1:10
2. 1:5
3. 1:3
4. 1:1
5. 1:20

/263./ Биондэвхжүүлэгчийг буй болгодог гадны хүчин зүйлүүдэд аль нь хамаарагддаг вэ?

1. Бага температур /2-4 0/
2. Туяаны энерги
3. Харанхуй нөхцөл
4. Химийн бодисын нөлөө
5. Эрхтэнг гэмтээх

/264./ Хатааж тосгүйжүүлсэн эрхтэний бэлдмэлд ямар нь хамаарагдах вэ?

1. Пепсин
2. Адиурекрин
3. Панкреатин
4. Тиреодин
5. Адонизид

/265./ Өтгөн хандыг цэвэрлэхэд ямар аргыг хэрэглэдэг вэ?

1. Буцалгаж цэвэрлэх арга
2. Спиртээр тунадасжуулах арга
3. Адсорбцын арга
4. Диализ
5. Электродиализ

/266./ Ургамлын түүхий эдээс үйлчлэгч бодисыг бүрэн гүйцэд хандлахад юу нөлөөлдөг вэ?

1. Түүхий эд экстрагентын харьцаа
2. Концентрацын ялгаа
3. Хандлах дэглэм
4. Температурын нөлөө
5. Түүхий эдийн жижиг хэсгийн хэмжээ

/267./ Флавоноид агуулсан бэлдмэлийг үйлдвэрийн аргаар ургамлаас гарган авахдаа флавоноидыг гол төлөв ямар хэлбэрээр ялгах вэ?

1. Давс
2. Гликозид
3. Комплекс
4. Агликон
5. Суурь

/268./ Нэрмэл усаар халаалт хэрэглэж хандлалт явуулахад илрэх дараах зүйлүүдээс аль нь хандлалтанд сайнаар нөлөөлөх вэ?

1. Уураг ихээр ялгарах
2. Коньюктив диффузи нэмэгдэнэ
3. Салс ялгарна.
4. Шингэний хөдөлгөөн идэвхжинэ
5. Цардуул хөвмөл үүсгэнэ

/269./ Хуурай хандны чанарыг ямар шалгууруудаар шалгадаг вэ?

1. Чийглэг
2. Хүнд металлын хэмжээ
3. Үйлчлэгч бодисын хэмжээ
4. Ялгамлын нягт
5. Спиртийн агууламж

/270./ Хандмал гарган авахад түүхий эд бэлэн бүтээгдэхүүний харьцаа ямар байдаг вэ?

1. 1:1
2. 1:5
3. 1:2
4. 1:10
5. 1:20

/271./ Тарилгын зориулалтаар хэрэглэх бэлдмэлийг цэвэрлэхэд ямар аргуудыг хэрэглэх вэ?

1. Хүчтэй электролиитоор цэвэрлэх
2. Органик уусгагчаар цэвэрлэх
3. Тунгаах арга

4. Халааж фракцлах арга

5. Диализ

/272./ Шинэхэн ургамлын түүхий эдээс ямар бэлдмэлүүд гарган авдаг вэ?

1. Хандмал

2. Ханд

3. Шүүс

4. Өтгөрүүлсэн шүүс

5. Ялгамал хэлбэрийн бэлдмэл

/273./ Бадааны 120 кг үндэснээс хичнээн хэмжээний шингэн ханд гарган авах вэ?

1. 240л

2. 1200 л

3. 600 л

4. 120 л

5. 360 л

/274./ Ферментийн гаралтай бэлдмэлийг ямар аргаар ариутгах нь хамгийн зохимжтой вэ?

1. Дулааны

2. Химийн

3. Өндөр даралтын дор ариутгах

4. Мембранан шүүлтүүрээр шүүх

5. Механик арга

/275./ Хандлах процессийн үед ямар үзэгдэлүүд явагдах вэ?

1. Диффузи

2. Уусах

3. Десорбц

4. Диализ

5. Талсжих

/276./ Түүхий эдийг хувааж хэд хэдэн перколяторт хийж хандлах аргад дараах аргуудаас аль хамаарагдах вэ?

1. Мацерац

2. Ремацерац

3. Перколяц

4. Реперполяци

5. Эсрэг урсгалаар хандлах

/277./ Шингэн хандыг ямар шалгууруудаар стандартчилдаг вэ?

1. Үйлчлэгч бодисын хэмжээ

2. Хуурай үлдэгдэл

3. Хүнд металлын хэмжээ

4. Чийглэг

5. Зуурамтгай чанар

/278./ Биомассаас эх уусмал болон жижиг хэсгүүдийг ямар аргаар салгадаг вэ?

1. Хроматографийн

2. Шүүх

3. Талсжуулах

4. Хурилтуурдах

5. Нэрэх

/279./ Амьтны гаралтай бэлдмэлийг гарган авахад хэрэглэгддэг түүхий эдийг ямар аргуудаар даршилдаг вэ?

1. Ацетоноор боловсруулах

2. Спиртээр боловсруулах

3. Сублимацын аргаар боловсруулах

4. -30-40° C-д хөлдөөх

5. 0-8° C-д хадгалах

/280./ Хандмалыг стандартчилахдаа спиртийн агууламжийг аль аргаар тодорхойлж болох вэ?

1. Нэрэх арга

2. Хлороформоор экстракцлах арга
3. Буцалгах арга
4. Спиртийн концентрацыг спектрофотометрээр тодорхойлох
5. Нягтыг тодорхойлох

/281./ Шинэ галены алкалойд агуулсан бэлдмэлүүдэд аль нь хамаарагдах вэ?

1. Аймалин
2. Лобесил
3. Эргометрин
4. Коргликон
5. Диоспонин

/282./ Өтгөн ханд бэлтгэхэд ялгамлыг ямар аргаар гарган авдаг вэ?

1. Эсрэг урсгалаар хандлах
2. Циркуляц
3. Перколяц
4. Хэсэгчилсэн мацерац
5. Идээшүүлэх

/283./ Эмийн бодисын уусах чанар юунаас хамаарах вэ?

1. Талстын бүтэц
2. Цэвэршилт
3. Жижиглэлтийн хэмжээ
4. Норгогдох чадвар
5. Хольц

/284./ Диффузлэгдэх бодисын хэмжээтэй шууд хамааралтай үзүүлэлтийг заах

1. Фазыг зааглагч гадаргуу
2. Диффузийн коэффициент
3. Концентрацийн ялгаа
4. Диффузи явагдах хугацаа
5. Диффузи явагдах үеийн зузаан

/285./ Ямар эмийн хэлбэрийн хувьд уусалт тодорхойлох шаардлагатай вэ?

1. Лаа
2. Шахмал
3. Капсул
4. Мөхлөг
5. Шуугидаг шахмал

/286./ Эмийг бэлтгэх технологийн ажиллагаа түүний эмчилгээний үйлдэлд нөлөө үзүүлэх үү?

1. Эмийг бэлтгэх бүх л технологийн ажиллагаа шинжлэх ухааны үндэстэй явагдах ёстой
2. Эмийг бэлтгэх технологийн ажиллагаа эмийн бодис бие махбодид аль болох тохиромжтой нөхцөлд чөлөөлөгдөж дээд зэргийн үр нөлөө үзүүлэхэд чиглэгдэх ёстой
3. Эмийг бэлтгэх технологи нь түүний эмчилгээний үр нөлөөг өөрчлөхгүй байх ёстой бөгөөд шимэгдэлтийг сайжруулах ёстой
4. Эмийг бэлтгэх технологийн үйл ажиллагаа түүний эмчилгээний үйлдэлд нөлөө үзүүлдэггүй
5. Эмийг бэлтгэх технологи нь түүний шимэгдэлтийг сайжруулах ба эмчилгээний үр нөлөөг өөрчилдөггүй

/287./ Хандлах аргаар ургамлаас эфирийн тосыг ялгах үед ямар хандлагчийг хэрэглэх вэ?

1. Этанол
2. Нүүрстөрөгчийн диоксид
3. Ургамлын тос
4. Цэцгийн тос
5. Парафин

/288./ Ходоод гэдэсний замд эмийн бодис шимэгдэхэд нөлөөлөх хүчин зүйлүүд юу вэ?

1. Эм зүйн хүчин зүйлүүд
2. Хоол хүнсний зүйл, тэдгээрийг боловсруулах замын бүрэлдэхүүн хэсэг
3. Эмийг даруулж уухад хэрэглэх шингэний хэмжээ

4. Нас хүйс
5. Өдрийн дэглэм

/289./ Хагас задралын үед нөлөөлөх хүчин зүйлийг нэрлэнэ үү

1. Эмийн бодисын тун
2. Шээсний рН
3. Өөр эм хослуулж хэрэглэсэн байдал
4. Өвчтөний нас
5. Өвчний шинж тэмдэг

/290./ Ямар эмийг жижиглэхэд эмчилгээний үйлдэл нь нэмэгдэх вэ?

1. Альдактон
2. Гризеофульвин
3. Ацетилсалицилийн хүчил
4. Эритромицин
5. Пенициллин G

/291./ Эмийн бодисын уусалтыг абсорбцын зарчим дээр үндэслэсэн багажаар тодорхойлоход липидны мембран болгож ямар уусгагчийг хэрэглэх вэ?

1. Хлороформ
2. Гексан
3. Бензол
4. Толуол
5. Этилийн спирт

/292./ Уусалт тодорхойлоход ашиглагдах шингэн орчингоор ямар уусмалыг ашиглаж болох вэ?

1. Буферын уусмал
2. Ходоодны зохиомол орчин
3. Нэрмэл ус
4. Хлортустөрөгчийн хүчлийн янз бүрийн концентрацитай уусмал
5. Хлортустөрөгчийн хүчлийн янз бүрийн концентрацитай уусмал

/293./ Биофармацийн хүчин зүйлүүдэд юу хамаарагдах вэ?

1. Эмийн хэлбэрийн төрөл
2. Технологийн процессын шинж чанар
3. Туслах бодисын шинж чанар хэмжээ
4. Фармакологийн идэвхт бодис
5. Баглаа боодлын материалын төрөл

/294./ Эмийн бодис биеэс ямар үндсэн замаар гадагшилдаг вэ?

1. Өтгөнөөр
2. Бөөрний замаар
3. Шүлсээр
4. Хөлсөөр
5. Хөхний сүүгээр

/295./ Шимэгдэлт нь хоорондоо холбоотой ямар үе шатаас тогтох вэ?

1. Эмийн хэлбэрээсээ эмийн бодис чөлөөлөгдөх
2. Шимэгдэх хэсэгт эмийн бодис диффузлэгдэж хүрч очих
3. Эмийн бодис шимэгдэх хэсгээс эсийн мембранаар нэвтэрч цус буюу тунгалагийн системд орно
4. Эмийн бодис үйлдэл үзүүлэх газартаа очно
5. Эмийн бодис бүх биеэр тархана

/296./ Мөхлөгжүүлэх аргаар үйлдвэрлэсэн шахмал эмийн шимэгдэлтэнд нөлөөлөх хүчин зүйлийг нэрлэнэ үү

1. Мөхлөгийн хэмжээ
2. Мөхлөгийг хатаах температур
3. Холбогч бодисын концентраци
4. Шахах даралт
5. Хэрэглэх тоног төхөөрөмж

/297./ Тетрациклины бүлгийн антибиотикийн шимэгдэлтийг ямар хүнсний бүтээгдэхүүн багасгах вэ?

1. Тараг
2. Мах
3. Талх
4. Өндөг
5. Цөцгийн тос

/298./ Метаболизмын 2-р үед ямар процесс явагдах вэ?

1. Амин бүлэг үүсэх
2. Хүхрийн хүчилтэй нэгдэх
3. Гидроксил бүлэг үүсэх
4. Глюкуроны хүчилтэй нэгдэх
5. Карбоксил бүлэг үүсэх

/299./ Эм зүйн хүчин болох эмийн бодисын физик төлөв байдалд ямар шинж чанарууд хамаарагдах вэ?

1. Эмийн бодисын уусалт
2. Эмийн бодисын жижиг хэсгийн хэмжээ
3. Талстын дүрс хувирал
4. Гадаргуугийн шинж чанар
5. Полиморф дүрс хувирал

/300./ Цөсний бүрэлдэхүүнд ордог бодисууд эмийн бодисын шимэгдэлтэнд хэрхэн нөлөөлдөг вэ?

1. Тосонд уусдаг эмийн бэлдмэлийн уусалтыг сайжруулдаг
2. Гэдсэнд уусдаг бүрхүүлтэй эмийн хэлбэрийн уусалтыг сайжруулдаг
3. Тосонд уусдаг бүрхүүлтэй эмийн уусалтыг сайжруулдаг
4. Тосонд уусдаг эмийн бэлдмэл, гэдсэнд уусдаг бүрхүүлтэй эмийн хэлбэр болон тосонд уусдаг бүрхүүлтэй эмийн бодисыг задалдаг
5. Усанд уусдаг эмийн бэлдмэл, гэдсэнд уусдаг бүрхүүлтэй эмийн хэлбэрийн уусалтыг сайжруулдаг

/301./ Организмд эмийн бодис биотрансформацид орох процесст ямар хүчин зүйлүүд нөлөөлдөг вэ?.

1. Нас
2. Хүний бие махбодийн онцлог
3. Хүрээлэн буй орчинд буй бусад янз бүрийн бодисууд
4. Өвчний шинж чанар
5. Өөр бусад эмийн нөлөө

/302./ Эмийн полиморф дүрс хувиралууд хоорондоо ялгагдах шинжийг заана уу

1. Уусах чадвар
2. Хайлах температур
3. Гадаргуугийн шинж чанар
4. Исэлдэх чадвар
5. Найрлага

